



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 04.

Эрдэнэт

Түрээсийн төлбөрийн хэмжээг шинэчлэн
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчийн байрны 1м2 талбайн түрээсийн төлбөрийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн батлагдсан түрээсийн төлбөрийн хэмжээг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудаас бусад аж ахуйн нэгж байгууллага, иргэн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс, улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдсүгэй.

3.Орон нутгийн өмчийн байрны дам түрээсийн орлогын 60 хувийг “Эрдэнэт сан”-гийн дансанд сар бүр төвлөрүүлэхийг түрээслүүлэгч, орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА